

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ. СОНГОХ ДААЛГАВАР**Санамж:**

1. Асуулт даалгавар бүрийг анхааралтай, дуустал уншиж гүйцэтгээрэй.
2. Сонгох даалгавраас зөвхөн нэгийг сонгоорой.

1. Дараах бодомжуудаас аль нь зөв бэ? /1 оноо/
 А. Нийгэм бол хүмүүсийн хамтын амьдралын дээд хэлбэр
 В. Нийгэм бол төрийн харилцаа С. Нийгэм бол хүмүүсийн соёлын харилцаа
 D. Нийгэм бол угсаатны харилцаа E. Нийгэм бол эдийн засгийн харилцаа
2. Нийгэм гэдэг нь хүмүүсийн харилцан үйлчлэлийн бүтээгдэхүүн гэж хэн тодорхойлсонбэ? /1 оноо/
 А. Т.Парсонс В. К. Маркс С. Г.Спенсер D. М.Вебер E. Нейл Смельзер
3. Нийгмийн харилцааг Формацийн онолоор хэн тайлбарласан бэ? /1 оноо/
 А. Л.Морган В. К.Маркс С. М.Вебер D. Э.Гидденс E. Г.Спенсер
4. Нийгмийн харилцааны ангилалд аль нь илүүц зүйл вэ? /1 оноо/
 А. Бие хүмүүс хоорондын В. Институт хоорондын С. Бүлэг нийтлэг хоорондын
 D. Гэр бүл хоорондын E. Гариг эрхсийн
5. Нийгмийн харилцааг дараах байдлаар задлан шинжилснээс аль нь зөв бэ? /2 оноо/
 А. Хүн ам зүйн харилцаа В. Бүлгийн харилцаа С. Угсаатны харилцаа
 D. Эдийн засаг, улс төр, социал, соёл, үнэт зүйлсийн харилцаа
 E. Иргэншлийн харилцаа
6. Нийгмийн амьдралын хүрээг ангилахад аль нь илүүц зүйл вэ? /1 оноо/
 А. Социал хүрээ В. Эдийн засгийн хүрээ С. Хүмүүнлэгийн хүрээ
 D. Улс төрийн хүрээ E. Оюун санааны хүрээ
7. Иргэн хүн сонгуульд оролцох нь нийгмийн аль хүрээний харилцаанд хамаарагдах вэ? /1 оноо/
 А. Социал хүрээ В. Эдийн засгийн хүрээ С. Хүмүүнлэгийн хүрээ
 D. Улс төрийн хүрээ E. Оюун санааны хүрээ
8. Цалин тэтгэвэрийн асуудал нь нийгмийн аль хүрээний харилцаанд хамаарагдах вэ? /1 оноо/
 А. Социал хүрээ В. Нийгэм соёлын хүрээ С. Иргэншлийн хүрээ
 D. Улс төрийн хүрээ E. Оюун санааны хүрээ
9. Хүмүүсийн амьдралын түвшинг ямар үзүүлэлтээр тодорхойлдог вэ? /2 оноо/
 А. Соёлын түвшин В. Нэг хүнд ноогдох бодит орлого С. Намын гишүүнчлэл
 D. Эдийн засгийн өсөлт E. Гэр бүлийн орлогын хэмжээ
10. Нийгмийн хэв маягуудтай шууд хамаарагдах харилцаануудад буруу холбоос орсонбол аль вэ? /3 оноо/
 А. Агнуурын нийгэм – Технологи – Маш энгийн, мод чулуу зэргийг ашигласан
 В. Энгийн тариалангийн нийгэм – Суурьшил – Үржил шимтэй газар сэлгэн нүүдэг
 С. Аж үйлдвэржсэн нийгэм – Эдийн засаг – Илүүдэл бүтээгдэхүүн үйлдвэрлэгддэггүй
 D. Газар тариалангийн нийгэм – Тэгш биш байдал – Хүн амын олонх нь ядуу тариачид
 E. Аж үйлдвэржсэний дараах нийгэм – Нийгмийн байгууллагууд – Шинжлэх ухаан
11. Нийгмийн хэв маягийг дараах байдлаар хэн ангилсан бэ? /Хүй нэгдлийн нийгэм, боол эзэмших нийгэм, феодалын нийгэм, капиталист нийгэм, коммунист нийгэм/ /1 оноо/
 А. Л.Морган В. М.Вебер С. Г.Ленски D. Д.Белл E. К. Маркс
12. Энгийн нийгмийн онцлогт аль нь илүүц зүйл вэ? /1 оноо/

- А. Хамтын өмчид тулгуурласан В. Ураг төрлийн харилцаа давамгайлсан
 С. Нийгмийн овгийн зохион байгуулалттай D. Машин, техник ашиглах болсон
 Е. Хөдөлмөрийн хуваарийн түвшин дорой
13. Иргэний нийгмийн үндсэн шинжид аль нь хамаарагдахгүй вэ? /1 оноо/
 А. Хүний эрх, эрх чөлөөг дээдлэх В. Төрийн зохицуулалттай зах зээл хөгжих
 С. Мэдээллийн хэрэгслийн эрх чөлөө D. Нийгмийн хяналт сулрах
 Е. Иргэдийн нийгмийн идэвх дээшлэх
14. "Улс төр бол төр улсын бүх ажил хэрэг" гэж хэн тодорхойлсон бэ? /1 оноо/
 А. К.Маркс В. М. Вебер С. Д.Истон D. Аристотель Е. Г.Лассуэл
15. Улс төр хүмүүсийн амьдралд хэрхэн холбогдох вэ? /1 оноо/
 А. Улс төр бол хамтын хэрэгцээ шаардлага
 В. Улс төр бол улс орноо гэх сэтгэл зориг үүрэг хариуцлагын нэгдэл
 С. Улс төр бол олныг хамарсан асуудал, шийдвэрлэх үйл явц
 D. Улс төр бол иргэд төрийг байгуулахад ухамсартай сонголт хийхэд нөлөөлдөг
 Е. Дээрх бүгд зөв
16. "Засаглал гэдэг нь эсэргүүцлийг ялан давж тухайн нийгмийн харилцаанд өөрийн хүсэл зоригийг хэрэгжүүлэх чадвар" гэж хэн үзсэн бэ? /1 оноо/
 А. В.И.Ленин В. К. Маркс С. М.Вебер D. Г.Лассуэл Е. Т.Парсонс
17. Эрх мэдлийн субъектийг тоочихдоо буруу зүйл дурдсан бол аль нь вэ?/1 оноо/
 А. Хувь хүн В. Улс төрийн институциуд С. Ард түмэн
 D. Нийгмийн бүлгүүд Е. Албадлага
18. Засаглалын нөөцийг хэрхэн ангилдаг вэ? /2 оноо/
 А. Эдийн засгийн нөөц В. Нийгмийн нөөц С. Соёл мэдээллийн нөөц
 D. Хүн ам зүйн нөөц Е. Бүгд зөв
19. Засаглалын уламжлалт легитим шинжид аль нь хамааралгүй вэ? /1 оноо/
 А. Ёс заншил В. Дэг журам С. Ашиг хонжоо
 D. Итгэл үнэмшил Е.Захирах захирагдах зуршил
20. Татвар төлөөд оронд нь эрүүл мэнд, боловсрол, нийгмийн халамжийн үйлчилгээтөрөөс авч байгаа нь эрх мэдлийн ямар хэлбэр вэ? /1 оноо/
 А. Хүч хэрэглэх эрх мэдэл В. Наймаалцах эрх мэдэл С. Үүрэг үүсгэх эрх мэдэл
 D. Ял шийтгэл оногдуулах эрх мэдэл Е. Нөлөөлөх эрх мэдэл
21. Улс төрийн системийн онолын загварыг анх хэн боловсруулсан бэ? /1 оноо/
 А. Т.Парсонс В. Д.Истон С. К.Маркс D. М.Вебер Е. Г.Лассуэл
22. Улс төрийн системийн цөм нь болдог үндсэн элемент аль нь вэ? /1 оноо/
 А. Иргэн В. Сонирхлын бүлэг С. Улс төрийн нам
 D. Төр Е. Хэвлэл мэдээлэл
23. Улс төрийн системийн бүрдэл хэсгүүдийг тоочихдоо илүүц зүйл оруулсан бол аль нь вэ?/1 оноо/
 А. Оролт В. Хувиралт С. Сонгууль D. Эргэх холбоо Е. Гаралт
24. Шийдвэр ба үйлдэл нь улс төрийн системийн ямар сувагт хамаарагдах вэ? /2 оноо/
 А. Гаралт В. Оролт С. Хувиралт D. Эргэх холбоо Е. Дотоод гадаад орчин
25. Сонирхлыг нэгтгэж улс төрийн бодлогын боломжийн хувилбарыг боловсруулж байдаг гол элемент аль нь вэ? /1 оноо/
 А. Төр В. Улс төрийн нам С. Төрийн бус байгууллага
 D. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл Е. Сонирхлын бүлэг
26. Иргэдийн улс төрийн оролцоо гэж юу вэ? /2 оноо/
 А. Шийдвэр гаргах үйл явцад нөлөөлөх иргэний үйл ажиллагаа

- В. Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эрхлэх С. Татвар төлөх
D. Өөрийгөө хөгжүүлэх E. Мэдээлэл дамжуулах
27. Олон ургальч ардчиллын үзэл санааны зарчмуудад аль хамааралгүй вэ? /3 оноо/
A. Нийгмийн доторх санаа бодлын илэрхийлэл болсон улс төрийн нам, үүргийг чухалчлах
B. Төр засаг нь ард түмнийхээ өмнө биш, харин нам, бүлгийн өмнө хариуцлага хүлээх
C. Төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэхэд нам, бүлгүүдийг тэгш оролцуулан зөвшилцлөөр нийгмийн нэгдмэл байдлыг хангах
D. Элит нь улс орныг захирдаг аль нэг талаараа шалгарсан давуу талтай хүмүүсээс бүрдэж ерийн олон түмнээс ялгарах
E. Шийдвэр гаргахад бүх хүнийг оролцуулах боломжгүй ч ардчиллын зарчмуудыг бодитойгоор хэрэгжүүлэх боломжтой
28. Цөөн хүн олонхийн тусын тулд засаглахыг Аристотель ямар засаглал гэж нэрлэсэн бэ? /1 оноо/
A. Олигархи B. Тирани C. Полити D. Аристократ E. Монархи
29. Нийгмийн эдийн засгийн хүрээн дэх гол зорилтыг дурдахдаа илүүц зүйл оруулсан болаль нь вэ? /1 оноо/
A. Юуг үйлдвэрлэх B. Яаж үйлдвэрлэх C. Хэнд зориулан үйлдвэрлэх
D. Нийгмийн халамж, хамгаалал E. Хичнээн хэмжээтэй үйлдвэрлэх
30. Өмч нь эдийн засгийн болоод хууль зүйн ойлголт юм. Доорх өгөгдлөөс аль нь эдийн засгийн талыг илэрхийлэх вэ? /2 оноо/
A. Өмчийг эзэмших B. Өмчийг ашиглах C. Захиран зарцуулах
D. Өмчийг арвижуулах E. Бэлэглэх
31. Тухайн барааны үнэ эрэлтийн тоо хэмжээ хоёрын урвуу хамаарлыг илэрхийлэн харуулдаг хуулийг.....гэнэ. Зөв өгөгдлийг нөхнө үү? /2 оноо/
A. Нийлүүлэлтийн хууль B. Эрэлтийн хууль C. Өмчийн харилцаа
D. Тэнцвэрт үнэ E. Эрэлт нийлүүлэлтийн зөрүү
32. Доорх өгөгдлүүдээс чөлөөт зах зээлийн эдийн засгийн тогтолцооны үндсэн шинжидаль нь хамааралгүй вэ? /1 оноо/
A. Хувийн өмч B. Ашгийн төлөө C. Хүн амын эмзэг хэсэгт чиглэсэн халамж
D. Төрөөс эдийн засгийн үйл явц дахь оролцоос бага E. Төрийн зохицуулалт
33. Хувь хүний хуулиар зөвшөөрөгдсөн монополь эрх гэж юу вэ? /2 оноо/
A. Албан тушаал, эрх мэдлээ урвуулан ашиглах онцгой эрх
B. Өөрийн зохиосон шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг ашиглах патентийн онцгой эрх
C. Компаниудын эрүүл өрсөлдөөнийг боймлох
D. Үйлдвэрлэгч жижиг аж ахуйн нэгжүүд зах зээлд нэвтрэн ороход бэрхшээл учруулах
E. Өөр хоорондоо эвсэн нэгдэж бараа үйлчилгээндээ монополь үнэ тогтоох
34. Хөдөлмөрийн зах зээл гэж юу вэ? /2 оноо/
A. Ажил хийх хүсэл чадвар байсан ч ажлын байр байхгүй байх
B. Боловсролтой, мэргэжилтэй хүмүүсийн хөдөлмөрлөх өрсөлдөөн
C. Ажиллах хүч, хөдөлмөр арилжигдах орон зай
D. Хөдөлмөр хийх цалинг тооцох
E. Хөдөлмөр эрхлэх орчин
35. Ажилгүйдлийг бууруулах арга замыг бүлэглэн илэрхийлэхдээ илүүц зүйл дурдсан болаль вэ? /2 оноо/
A. Эдийн засгийн аргаар B. Нийгмийн халамжийн аргаар C. Захиргааны аргаар
D. Гадаад хүчин зүйлсийг ашиглах замаар
E. Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх замаар
36. Улсын төсөв бүрдүүлдэг татварын орлогод доорх өгөгдлүүдийн аль нь онцхамааралгүй вэ?

/1 оноо/

- A. Орлогын албан татвар B. Нийгмийн даатгалын орлого C. Гаалийн албан татвар
D. Хүү, торгуулийн орлого E. Онцгой албан татвар

37. Татварын тогтолцооны элементүүдийг холбогдох өгөгдлүүдтэй нь зөв харгалзуулнауу? /3 оноо/

а	Албан татвар	1	Үйлчилгээ үзүүлсний төлөө төсөв, эсвэл тусгай санд төвлөрүүлж байгаа мөнгөн хөрөнгө
в	Төлбөр	2	Тогтоогдсон хувь хэмжээгээр улс орон нутгийн төсөвт оруулж байгаа мөнгөн хөрөнгө
с	Хураамж	3	Өмч ашиглуулсны төлөө төсөв, эсвэл тусгай санд төвлөрүүлж байгаа мөнгөн хөрөнгө

- A. а1 в2 с3 B. а3 в2 с1 C. а2 в3 с1 D. а2 в1 с3 E. а3 в1 с2

38. Мөнгөний үндсэн үүргүүдийг тоочихдоо буруу зүйл дурдсан бол аль нь вэ? /1 оноо/

- A. Төлбөрийн хэрэгсэл B. Гүйлгээний хэрэгсэл C. Бэлэн бус мөнгө / чек, карт/
D. Өртгийн хэмжүүр E. Хуримтлалын хэрэгсэл

39. Төв банкны хамгийн гол зорилтыг тэмдэглэнэ үү? /2 оноо/

- A. Мөнгөн тэмдэгт гүйлгээнд гаргах
B. Арилжааны банкны үйл ажиллагаанд хяналт тавих
C. Банк хоорондын тооцоог зохицуулах
D. Улсын эдийн засаг дахь мөнгөний тогтвортой байдлыг хангах
E. Гадаад валютын улсын нөөцийг эзэмшин, зохицуулах

40. Улс орны эдийн засгийн хөгжлийн өсөлт, чадавхийг тодорхойлдог гол үзүүлэлт аль нь вэ?/2 оноо/

- A. Дотоодын нийт бүтээгдэхүүн B. Үндэсний цэвэр бүтээгдэхүүн
C. Үндэсний нийт орлого D. Нэг хүнд ноогдох үндэсний нийт бүтээгдэхүүн
E. Үндэсний орлого

41. Далд эдийн засгийн хэлбэрүүдийг нэрлэхдээ илүүц зүйл дурдсан бол аль вэ? /1 оноо/

- A. Ажил эрхэлдэггүй орлого ологчид
B. Давхар ажил эрхлэгчид ба хууль бус бизнесийн үйл ажиллагаа
C. Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчид D. Авилга, хээл хахууль авах
E. Өмч идэж шамшигдуулах, хэрэглэгчдийг мэхлэж орлого олох

42. Малчны хүү Болдоо БИС-ийг багшийн мэргэжлээр дүүргээд улмаар УБ хотын нэгэн сургуульд багшийн ажил хийж байгаад БШУЯ-ны агентлагт хариуцлагатай ажиллажиж байна. Энэ нь нийгмийн шилжих хөдөлгөөний ямар төрөлд хамаарагдах вэ? /2 оноо/

- A. Үе доторх B. Нутаг дэвсгэрийн C. Үе хоорондын D. Гэр бүлийн E. Бүтцийн

43. Оюутан хүн сургалтын тэтгэлэг авах нь нийгмийн даатгалын аль төрлийн сангийн даатгалд хамаарагдах вэ? /2 оноо/

- A. Тэтгэврийн даатгал B. Тэтгэмжийн даатгал
C. Эрүүл мэндийн даатгал D. Ажилгүйдлийн даатгал
E. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгал

44. Сайн дураараа даатгуулах нийгмийн даатгалын хэлбэрт аль нь орохгүй вэ? /1 оноо/

- A. Хувийн аж ахуйтан-малчид, тариаланчид C. Ажилгүй хүмүүс
B. Хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэд, эзэд E. Төрийн албан хаагч
D. Чөлөөт уран бүтээлчид

45. Нийгмийн давхраажлын тогтолцоон доторх хүмүүсийн хөдөлгөөнийг юу гэдэг вэ?/1 оноо /

- А. Газар зүйн шилжих хөдөлгөөн В. Бүтцийн шилжих хөдөлгөөн
 С. Нийгмийн шилжих хөдөлгөөн D. Үе хоорондын шилжих хөдөлгөөн
 E. Үе доторх шилжих хөдөлгөөн
46. 1990 оноос хойш манай орны баруун, зүүн хязгаараас хүн ам төврүүгээ шилжин нүүдэллэх болсон нь шилжих хөдөлгөөний ямар ангилалд хамаарах вэ? /2 оноо/
 А. Шашин сүсэг бишрэлийн В. Нутаг дэвсгэрийн С. Үе хоорондын
 D. Улс төрийн E. Гэр бүлийн
47. Дондог нэгэн улсын байгууллагад жолоочийн ажилтай байжээ. Өмч хувьчлалын дарааг байгууллага хувьчлагдаж ажлаасаа гарчээ. Тэрээр одоо нэгэн компанид мөн жолоочажилтай болсон. Энэ нь шилжих хөдөлгөөний аль хэв маягт хамаарагдах вэ? /2 оноо/
 А. Босоо В. Хэвтээ С. Маргинал хөдөлгөөн D. Нутаг дэвсгэрийн E. Бүлгийн
48. Нийгмийн халамжийн тэтгэврийн төрөлд аль нь хамаарагдах вэ? /1 оноо/
 А. Ахмад настны халамжийн тэтгэвэр
 B. Жирэмсэн эхэд олгох тэтгэмж
 C. Ахмад настныг асарч буй иргэнд олгох тэтгэмж
 D. Хүүхдийн нөхцөлт мөнгөн тэтгэмж
 E. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч буй иргэнд олгох тэтгэмж
49. Хүний бүтээсэн болон бүтээж байгаа, хүн өөрийгөө хүн болгон төлөвшүүлэх эд өлгийнболон оюуны үнэт зүйлсийн цогцолборыг.....гэнэ. /1 оноо/
 А. Шашин В. Шинжлэх ухаан С. Соёл D. Урлаг уран сайхан E. Ёс заншил
50. Соёлыг бүрдүүлэгч зүйлүүдэд аль нь орох вэ? /1 оноо/
 А. Эд өлгийн үнэт зүйлс В. Шашин шүтлэг С. Итгэл үнэмшил
 D. Хэл, мэдлэг E. Бүгд зөв
51. Боловсролын түвшнээс хамааралгүйгээр нийгмийн бүх бүлэг, давхраа, бүх насныханд хүртээмжтэй байдаг соёлын хэлбэрийг олж тэмдэглэнэ үү /1 оноо/
 А. Элитийн соёл В. Ардын соёл С. Нийтийн соёл D. Дагуул соёл E. Сөрөг соёл
52. Доорх өгөгдлөөс өөрийн гэсэн өвөрмөц шинжүүдтэй, нийгмийн тухайн бүлгийн амьдрал, үйл ажиллагааны онцлогтой дэд соёлд аль нь хамааралгүй вэ? /1 оноо/
 А. Үндэсний В. Шашны С. Мэргэжлийн D. Үндэсний цөөнхийн E. Ардын
53. Олон улсын харилцааны үндсэн хэлбэрүүдэд аль нь хамааралгүй вэ? /1 оноо/
 А. Эдийн засгийн В. Байгууллагын С. Соёлын D. Цэргийн E. Улс төрийн
54. НҮБ-ын үндсэн зорилтуудыг нэрлэхдээ илүүц зүйл оруулсан бол аль нь вэ? /2оноо/
 А. Дэлхий дахинд энх тайван аюулгүй байдлыг сахин хангах
 B. Үндэстэн улс орнуудын хооронд найрсаг харилцааг хөгжүүлэх
 C. Гадаад худалдааг хөгжүүлж ашиг олох
 D. Хүний эрх, эрх чөлөөг зөрчих явдалтай тэмцэх
 E. Бичиг үсэг үл мэдэх явдал, өвчин эмгэг, өлсгөлөн ядуурлыг даван туулахад туслах
55. Монгол улсын гадаад бодлогын эн тэргүүний зорилтыг тэмдэглэнэ үү /2оноо/
 А. Ази номхон далайн улс орнуудтай харилцах
 B. АНУ ба өрнөдийн хөгжингүй орнуудтай харилцах
 C. ОХУ, БНХАУ-тай найрсаг, сайн хөршийн хамтын ажиллагаа хөгжүүлэх
 D. Посткоммунист орнуудтай харилцах
 E. Дэлхийн бүх улс оронтой харилцаж, хамтын ажиллагаа хөгжүүлэх
56. Монгол улс дэлхий дахинд хэдий үеэс эхлэн нээлттэй гадаад бодлогын үйл ажиллагаа хэдэн оноос явуулж байна вэ? /1 оноо/
 А. 1920-иод В. 1940-өөд С. 1960-аад D. 1990-ээд E. 2000-аад

ХОЁРДУГААР ХЭСЭГ. ХАРГАЛЗУУЛАХ ДААЛГАВАР

Санамж:

1. Энэ хэсэг сонгох даалгавар биш тул харгалзааг зөв тогтоож хариуг бөглөөрэй.
2. Зөв харгалзуулсан хариулт бүр 1 оноотой.

2.1 Доорх өгөгдлүүдийг зөв харгалзуулна уу?

/5 оноо/

a	Чөлөөт шударга сонгууль	1	Ард түмний олонх улс орныг удирдаж байхад цөөнхийн эрхийг хамгаалах
в	Иргэдийн оролцоо	2	Хүн бүр хуулийг сахих, зөрчвөл хариуцлага хүлээх
с	Хуульд захирагдах ёс	3	Иргэд өөрсдийнхөө төлөө шийдвэр гаргах үйл ажиллагаанд идэвхтэй оролцох
d	Улстөрийн хүлээцтэй байдал	4	Иргэд төр, засагт өөрсдийн төлөөллийг чөлөөтэй, шударгаар сонгох, өөрчлөх
e	Нийтэд ил тод байх	5	Төр засаг ард түмэндээ ажлаа тайлагнах, улс орны байдал хөгжлийн талаар мэдээлэх

2.2 Доорх өгөгдлүүдийг зөв харгалзуулна уу?

/5 оноо/

a	Эдийн засгийн тогтолцоо	1	Эдийн засагт төрийн оролцоо байх ёстойг илэрхийлсэн Ж.Кейнсийн үзэл
в	Чөлөөт зах зээл	2	Зан заншил уламжлалдаа тулгуурласан эдийн засгийн тогтолцоо
с	Холимог тогтолцоо	3	Хувийн өмчийг хамгаалах, ашиг олох, төрөөс эдийн засгийн үйл явц дахь оролцоо хязгаарлагдмал
d	Уламжлалт эдийн засаг	4	Хүмүүсийн хэрэгцээг хангахын тулд хязгаарлагдмал нөөцийг хуваарилахад ашиглаж буй зохион байгуулалтын уялдаа зохицол
e	Төрийн зохицуулалт	5	Хувийн өмч, зах зээл, нийгмийн өмч, төвлөрсөн төлөвлөлт дээр тулгуурлах

2.3 Доорх өгөгдлүүдийг зөв харгалзуулна уу?

/5 оноо/

a	Давхраажил	1	Нэр хүнд, эрх мэдэл, эд баялаг, боловсрол
в	Давхраажлын хэмжигдэхүүн	2	Нийгмийн анги бүлгүүд нэг нь нөгөөгөөсөө нэр хүнд, эд баялаг, эрх мэдэл, боловсролоороо дээр юмуу, доор байрлах байдал
с	Давхраажлын үндсэн хэв маяг	3	Дээд, дунд, доод
d	Анги	4	Брахман, кшатри, вайшы, шудра
e	Каст	5	Боолчлол, каст, язгуур, анги

2.4. Доорх өгөгдлүүдийг зөв харгалзуулна уу?

/5 оноо/

a	Бэлгэ тэмдэг	1	Хүмүүс ямарч үед байнга дагаж мөрдөж байх үйл, төрх байдлын ерөнхий дүрэм
в	Хэл	2	Болзмол шинжтэй дуу, авиа болон тэмдгүүдийн оролцоотойгоор хэрэгждэг мэдээллийн тогтолцоо
с	Үнэлэмж	3	Нийгэм, нийгмийн бүлгийн гишүүд нийтээр хүлээн зөвшөөрөн нэг объект, үйлдлээр нөгөөгийн утга учрыг илтгэх, илэрхийлэх үйлдэл, объект
d	Хэм хэмжээ	4	Тодорхой хэмжээгээр хамтын мэдрэмж төрүүлдэг, хэвшмэл болон бэлгэдлийн шинжтэй үйлдлүүдийн цогц
e	Зан үйл	5	Хүнд зайлшгүй хэрэгтэй, бүгдээс илүү дээгүүр гэдгийг хүлээн зөвшөөрч, түүнд тэмүүлж, ихэд хүндэтгэн дээдэлж, биширч харилцдаг хүний мэдрэмж, амьдралын үнэт чиглэл